

Хойд Солонгосын заналхийллийг “догшин галаар” угтана

Катрина Мансон

АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трамп Пхеньяны заналхийллийн дараа “Дэлхийд өмнө үзэгдээгүй догшин галаар угтана” хэмээн мэдэгдсэн. Үүний дараа Хойд Солонгосын мэдээллийн агентлаг Номхон далай дахь Америкийн Гуам аралд цохилт өгөх тухай Ким Жон Ун тунгааж байна гэж мэдээлэв. Уг тайлбар АНУ-ын зүгээс Умардын цөмийн ба пуужингийн хөтөлбөрийг зогсоохын төлөө тэмцэж буй үед асуудлыг бүр ч хурцатгалаа. Солонгосын ардын армийн хэвлэлийн төлөөлөгч хэлэхдээ дээд удирдагч Японоос урагш оршдог 200 мянга гаруйхан хүн амтай арлыг онилох шийдвэр нэгэнт гаргасан тул “Цохилтын төлөвлөгөөг олон чиглэл, дэс дараалалтайгаар ямар ч үед хэрэгжүүлэхээр боловсруулна” гэжээ.

Хойд Солонгос баллистик пуужинг цэнэглэж болохуйц жижиг цөмийн бөмбөг бүтээсэн тухай мэдээ цацагдсаны дараа ноён Трамп “Хойд Солонгос Америкийг дахиад заналхийлэхгүй байвал дээр дээ” гэж анхааруулсан юм. Гэвч Ерөнхийлөгчийн үгийг улс төрийн өрсөлдөгчид нь шүүмжилсэн байна. Тухайлбал, Сенатын цэргийн бодлогын хорооны дарга Жон МакКэйн “Хийнэ гэсэн зүйлээ хийж чадах, эсэхэд нь эргэлзэж байгаа учир би Ерөнхийлөгчийн үгийг эсэргүүцэж байна. Энэ нь АНУ-ыг мөргөлдөөнд улам ойртуулна” хэмээв.



BVM©

АНУ-ын Батлан хамгаалахын сайд Жеймс Маттис тэргүүтэй цэргийнхэн Хойд Солонгосын цөмийн ба энгийн зэвсэглэл, биохимийн дайралт нь Вашингтоны холбоотон болох Өмнөд Солонгос, Японы нутагт хүрэх хүчин чадалтай учир Умардтай хийх дайны өртөг төсөөлөхын аргагүй өндөр болохыг анхааруулж буй. Үүний зэрэгцээ Пхеньяны пуужин АНУ-

ын нутагт хүрч болзошгүй гэх түгшүүр нэмэгдлээ. Америкийн тагнуулын 17 албаны нэг Батлан хамгаалах тагнуулын агентлагаас гаргасан дүгнэлтэд “Хойд Солонгос баллистик пуужинд зориулсан жижиг цөмийн хошуу бүтээсэн тул тив алгасах пуужин цэнэглэх боломжтой” хэмээн дурдсан тухай мэдээ таржээ. Тагнуулын албад Пхеньян 60 шахам цөмийн зэвсэгтэй гэж

тооцож байгаа аж.

Тагнуулын төв газрын шинжээч асан Брюс Клигнер “Хойд Солонгосын пуужингийн туршилтууд бүтэлгүйтэж байсан тул бусад улсын бүтээснийг хийж чадахгүй гэж үзсэнээс олон жилийн турш тэдний аюулыг дутуу үнэлсэн. Харин тагнуулын албад тус дарангуйлагч дэглэмийг үргэлж хатуугаас хатуу бай гэж үздэг” хэмээн

тайлбарлав. Түүнчлэн Вудроу Вильсоны төвийн олон улсын аюулгүй байдлын судалгааны захирал бөгөөд Пхеньяны цөмийн чадамжийг тусгайлан судалсан Роберт Литвак Хойд Солонгосыг АНУ-ын нутаг дэвсгэрт заналхийлэх томоохон алхам хийлээ гэж дүгнэсэн байна.

Тэрбээр “Хойд Солонгос цөмийн салбартаа эргэлт хийх

цэг дээр ирсэн. Гэвч технологийн хөгжлийн энэхүү шугамыг өөрчлөх хугацаа бий. АНУ гэхэд л нарийн төвөгтэй, нийлмэл технологийг бүтээхэд олон жил зарцуулж байв. Иймээс улс төр, дипломат арга хэмжээ авах боломж байгаа. Цөмийн хөтөлбөрийг царцаах нь дипломат харилцааны том амжилт болно” хэмээв.

FT

Япон аюулын зэрэглэлээ нэмэгдүүлэв

Лео Льюс

Японы Засгийн газар Хойд Солонгост өгөх албан ёсны сануулгаа шат ахиулж, “Аюулын зэрэглэл шинэ түвшинд гарлаа” гэж мэдэгдэв. Дарангуйлагч дэглэм цөмийн зэвсгийн оврыг багасгах чадамжтай болсон байж магадгүйг энд дурджээ. Японы жил бүрийн батлан хамгаалахын цагаан номонд Хятадыг онцлоод “Тус улс одоогийн тэнцвэрийг хүч хэрэглэн өөрчлөхийг оролдож байна” хэмээн тэмдэглэв. Өмнөх оны тайлангаас хойш Пхеньян хоёр удаа цөмийн туршилт хийж, 20 гаруй баллистик пуужин хөөргөсөн тул аюулын зэрэглэлийг эргэн харсан байна. Цагаан номонд “Хойд Солонгос цөмийн зэвсгээ хэдийнэ жижигрүүлж, цөмийн хошуу бүтээсэн байж болзошгүй” хэмээн дүгнэжээ.



BVM©

Энд Японы батлан хамгаалахын эн тэргүүний зорилтыг тодорхойлохдоо “тогтворгүй-жүүлэгч хүчин зүйлүүд илүү бодитой, хурц” болсноор аюулгүй байдлын орчин улам ширүүсэж буйг онцлов. Дахин томилогдсон Японы Батлан хамгаалахын сайд Ицунори Онодера тус улс гадаадын пуужингийн баазд цохилт өгөх технологитой болох ёстой

хэмээн мэдэгдсэн юм. Ийм технологи бүтээхэд олон жил шаардлагатай боловч Японы батлан хамгаалах бодлогод эрс өөрчлөлт орох дохио болов. Гэвч дэмжлэг нь сулраад буй Ерөнхий сайд Шинзо Абэ Үндсэн хуульд өөрчлөлт оруулах асуудлыг хойш тавиад байгаа. Тэрбээр Японы өөрийгөө хамгаалах хүчинд Хойд Солонгосын пуужингийн байрлалд цохилт өгөх төлөвлөгөө боловсруулах зөвшөөрөл олгох бодолгүй байна гэж мэдэгдсэн.

Гэвч зарим шинжээч ноён Абэ болон түүнийг залгамжлагч Хойд Солонгосын аюулыг сөрөх бодлогын өөрчлөлт хийхэд хүчтэй эсэргүүцэхгүй байх гэж үзэж байна. Японд хүрэх хүчин чадалтай пуужин туршсаны дараа тус улсад түгшүүрийн дохиогоор ажиллах, нүүдлэн шилжүүлэх сургуулилалт хийхэд хүрсэн. Энэ

нь олон нийтийн санаа бодолд нөлөөлж, дайралтын зэвсэгтэй болох дэмжлэгийг нэмэгдүүлэх боломжтой. Ноён Онодера дахин томилогдсоныхоо дараа хэвлэлийн бага хурал хийж “Японы ард иргэдийн амар амгалан, амь насыг хамгаалах бодлого чиглэлээ эргэн нягталж, судлахад зогсолтгүй хүчин чармайлт тавина” хэмээн мэдэгдсэн билээ.

FT



BVM©

Эх оронч кино Хятадад блокбастер боллоо

Том Хэнкок

“Хятад улсыг доромжилсон хэн ч бай, шийтгэлээ амсана” гэсэн утга бүхий эх оронч экшн кино БНХАУ-д хамгийн өндөр орлоготой дэлгэцийн бүтээл боллоо.

“Дайчин чоно 2” (Wolf Warrior 2) кинонд Ардын чөлөөлөх армийн элит байлдагч явсан эр Африк дахь хятад иргэдийг америкчуудаар удирдуулсан дээрэмчдээс хамгаалж буй тухай гарна. Өнгөрсөн долоо хоногийн эцсийн байдлаар уг кино 161 сая ам.долларын цэвэр ашиг олжээ.

Дэлгэцнээ гарснаас хойш 11 хоногт 470 сая ам.долларын орлого олсон уг бүтээл Хонконгийн инээдмийн киноны од Стивен Чоугийн “Лусын дагина” (The Mermaid) бүтээлийн амжилтыг эвдэж магадгүй байна. Өнгөрсөн онд гарсан “Лусын дагина” нийт 527 сая ам.долларын орлого олж, Хятадад борлуулалтаараа томоохон амжилт тогтоосон юм.

“Ирэх мягмар гараг гэхэд хуучин амжилтыг бараг эвднэ. Ийм их орлого ингэж хурдан

орно гэж хэн ч төсөөлөөгүй” хэмээн кино урлагийн мэдээллийн гол хэрэгсэл China Film Insider-ийн Жонатан Папиш бичжээ.

БНХАУ гадаад дахь анхны цэргийн баазаа Дорнод Африкийн Жибутид байгуулснаас хойш хэдхэн долоо хоног өнгөрч байхад уг бүтээл дэлгэцнээ гарлаа. Мөн БНХАУ-ын Ардын чөлөөлөх арми байгуулагдсаны 90 жилийн ойг тэмдэглэж буй эх оронч баярын уур амьсгал дунд энэ бүтээл үзэгчдийн хүртээл болж байна. “Эх оронч, үндэсний үзлийг нэвт шингээсэн уг кинонд сэтгэл догдлуулсан хэсэг олон” хэмээн Хятадын киноны Mtime цахим хуудаст нэгэн үзэгч бичжээ. “Энэ кино Хятад улс дэлхийд хүчирхэг гүрэн болсныг харууллаа” хэмээн өөр нэгэн тайлбарлав.

“Попкорн идэнгээ үздэг, хөнгөн чанарын, зугаатай кино. Тэгсэн хэрнээ эх оронч агуулгатай. Сүүлийн хоёр сард хүмүүст үзэх олигтой кино олдохгүй байсан юм” хэмээн Нанжин

хотын оршин суугч, 24 настай Чи Чю өгүүлэв.

БНХАУ-д зуны улиралд кино театруудаар гаднын УСК гаргахыг хориглодог

Сильвестр Сталлонегийн The Expendables, Marvel-ийн Captain America зэрэг блокбастерынх шиг тусгай эффект, тулалдаант үзэгдэл “Дайчин чоно 2”-ын сонирхол татах гол зүйл нь. Үйл явдлын өрнөл нь Хятадын гадаад бодлогыг магтсан, Африк дахь өрнөдийнхний үйлдлийг шүүмжилсэн агуулгаар хөвөрнө. Эцэст нь, Хятадын паспорт дэлгэцнээ тодроход хилийн чанадад ийм паспорт өвөрлөсөн иргэд ямар азтай вэ гэсэн бичиг дурайна.

Уг бүтээл Хятадын кино сонирхогчдын ортал үе болдог билгийн тооллын сар шинийн

баяртай давхцаж чадаагүй ч амжилттай борлогдож чадлаа.

Хятадын зохицуулах байгууллагууд зуны улиралд дотоодын бүтээлүүдийн борлуулалтыг тус улсын кино театруудын жилийн орлогын тал хувьд хүргэх үүднээс гадаадын шинэ кино гаргахыг түр зогсоодог.

Уг киноны найруулагч Ву Жин өөрөө тоглосон гол дүр нь “жинхэнэ хятад экшн од” мөн гэж ноён Папиш тайлбарлав. “Энэ киноноос өмнө хятадуудад жинхэнэ өөрийн гэсэн экшн од үнэхээр байгаагүй” хэмээн тэрбээр нэмж өгүүлсэн юм.

Ардын чөлөөлөх армийн 90 жилийн ойд зориулж, төрийн дэмжлэгээр бүтээсэн Founding of an Army кино уг бүтээлтэй харьцуулахад амжилт нь тааруу байна. Шинэхэн тодорсон поп оддыг цэргийнхний дүрд тоглуулснаас болж Ардын чөлөөлөх армийн хуучин дарга нарын шүүмжлэлийн бай болсон уг бүтээлийн борлуулалт “Дайчин чоно 2”-ыг гүйцсэнгүй.

FT